

Телевизийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн хугацаа сунгуулах өргөдлийн маягтын Нэгдүгээр хэсэрт

ТЕЛЕВИЗИЙН ҮЙЛЧИЛГЭЭ ЭРХЛЭХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ГЭРЭЭ, НӨХЦӨЛ, ШААРДЛАГЫГ ХЭРЭГЖҮҮЛЖ АЖИЛЛАСАН ТУХАЙ ТАЙЛАН

(Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.2.3-т заасны дагуу)

№	Заалтын дугаар	Холбогдох заалтууд	Телевизийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн төрөл (тухайн төрөлд + тэмдэг хамааралтай заалтуудын хэрэгжилтийг тайлагнана.)				Тайлбар
			Өргөн нэвтрүүлгийн телевиз	Арилжааны телевиз	Теле худалдааны телевиз	Төлбөртэй телевиз	
	А	Тусгай зөвшөөрлийн гэрээний хэрэгжилтийн байдал					
1	НШ 4.6	4.6 Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь Зохицуулах хорооноос хийгдсэн хяналт, шалгалтын дүнд илэрсэн аливаа зөрчил дутагдлыг тогтоосон хугацаанд арилгах үүрэгтэй.	+	+	+	+	Хяналт шалгалтаар болон албан бичгээр зөрчил дутагдлыг арилгах талаар хүргүүлсэн мэдэгдлийн дагуу авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, зөрчлийг хэрхэн арилгасан талаар
2	НШ 4.8	Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь хүүхдийг зохисгүй агуулгаас хамгаалахад чиглэсэн радио, телевизийн хөтөлбөрийн дүрмийг мөрдөх, уг дүрмийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан Зохицуулах хорооноос хүргүүлсэн зөвлөмж, шаардлагыг биелүүлж ажиллах үүрэгтэй	+	+	+	+	Зохицуулах хорооноос хүргүүлсэн зөвлөмж, шаардлагыг хэрхэн биелүүлж ажилласан талаар
3	НШ 4.9	Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь үйлчилгээний нөхцөл, тарифийг ил тод, олон нийтэд нээлттэй мэдээлнэ.	+	+	+	+	Холбогдох мэдээллийг өөрийн албан ёсны вэб сайтад мэдээлсэн байх, үзэж шалгах линкийг бичиж ирүүлэх
4	НШ 5.4 НШ 6.2	Статистик тайлан мэдээ ирүүлсэн байдал Зохицуулалтын үйлчилгээний хөлс төлсөн байдал	+	+	+	+	Статистик тайланг хугацаанд нь ирүүлсэн эсэх, Өр төлбөргүй эсэхийг үнэлгээнд авч үзнэ.
	Б	Телевизийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлага хангаж ажилласан байдал					
5	НШ 3.16	3.16 Үйлчилгээ эрхлэгч өөрийн хөтөлбөрөөр нэвтрүүлэх нэвтрүүлэг, киноны агуулгад насны ангилал тогтоох чиг үүрэг бүхий зөвлөл эсхүл ажлын хэсэгтэй байна.	+	+	-	+	Зөвлөл эсхүл ажлын хэсэг байгуулсан тушаал шийдвэр, үйл ажиллагааны талаарх мэдээллийг ирүүлнэ.
6	НШ 3.20	3.20 Монгол хэл бичгийн хянан найруулах чиг үүргийг холбогдох ажилтны ажлын байрны тодорхойлолтод тусган үүрэгжүүлсэн байна.	+	+	+	+	Монгол хэл бичгийн хянан найруулах чиг үүргийг ажил үүргийн хуваарийн дагуу хариуцаж буй ажилтны ажлын байрны тодорхойлолт, тушаал гарсан огноо, дугаар, хэрхэн ажилладаг талаар . Сунгалтын маягтын 3 -т заасныг мөн бөглөх
7	НШ 3.22.1	3.22.1 Телевизийн хөтөлбөрийн бодлого, онцлог тохирсон нэвтрүүлэг бэлтгэх, дамжуулахад шаардагдах техникийн иж бүрдлийг хангасан, MNS 5592-1, MNS 5592-2 стандарт болон норматив шаардлагад нийцсэн байх;	+	+	+	+	Сунгалтын маягтын 4,5-т заасан хүснэгтийг бөглөж ирүүлэх

8	НШ 3.22.3	3.22.3 Эфирийн бүрэн бичлэг болон метадатаг (эсхүл лог) хөтөлбөр дамжуулснаас хойш 60 хоног ба түүнээс дээш хугацаагаар архивлан хадгалах;	+	+	+	+	Хөтөлбөрийг архивладаг хугацаа, архивын ямар сервер, програм хангамж ашигладаг тухай мэдээлэл, метадата хадгалдаг эсэх
9	НШ 3.24	3.24 Үйлчилгээ эрхлэгч нь гамшгийн үед нэгдсэн удирдлага, дотоод зохион байгуулалтыг хангаж ажиллах ба байгууллагын гамшгаас хамгаалах төлөвлөгөөг гамшгаас хамгаалах мэдээлэл, харилцаа холбооны улсын албанаас гаргасан төлөвлөгөөтэй уялдуулан боловсруулж, батална.	+	+	+	+	Байгууллагын гамшгаас хамгаалах төлөвлөгөөтэй эсэх, баталсан тушаал, шийдвэрийн дугаар
10	НШ 3.25	3.25 Үйлчилгээ эрхлэгч нь мэргэжлийн инженер, техникийн ажилтантай байна.	+	+	+	+	Үйл ажиллагаа явуулахад шаардагдах ИТА- ны талаарх мэдээлэл, маягт 3-ийг бөглөж, НДШТ барим буюу НД8 маягтаар ирүүлэх.
11	НШ 4.4	4.4 Телевизийн эфирийн тасралтгүй ажиллагааны түвшин (TAT) сар бүр 99.8%-иас доошгүй байна.	+	+	+	+	ХХЗХ-нд сар бүрийн тайлангаа ирүүлсэн эсэх болон мониторингийн дүнгээр илэрсэн эфирийн тасалдалтын байдлыг үнэлгээнд харгалзан үзнэ.
12	НШ 4.7	4.7 Студийн гаралт дахь дууны чанга дуугаралтын (loudness) түвшинг хянаж, тохируулах боломжийг үе шаттай бүрдүүлж, Европын өргөн нэвтрүүлгийн холбооноос баталсан EBU R128 зөвлөмж, Монгол Улсын үндэсний стандартыг мөрдөж ажиллана.	+	+	+	+	Зөвлөмжийг хэрхэн хангаж ажилладаг болон дууны түвшинг хянаж, тохируулахад ашигладаг тоног төхөөрөмжийн талаарх мэдээллийг ирүүлэх. Зохицуулах хорооны хяналт, шалгалтанд хамрагдсан бол дүнг үнэлгээнд харгалзан үзнэ.
13	НШ 4.9	4.9 Дууны түвшинг хянах, тохируулах үүрэгтэй орон тооны ажилтантай байна.	+	+	+	+	Дууны түвшинг хянах, тохируулах чиг үүргийг ажил үүргийн хуваарийн дагуу хариуцаж буй ажилтны ажлын байрны тодорхойлолт, тушаал зэрэг холбогдох мэдээллийг ирүүлнэ. Маягт 3-т тусгах
14	НШ 5.4	5.4 Үзэгчдээс телевизийн үйл ажиллагаа, хөтөлбөртэй холбоотой санал, өргөдөл, гомдол хүлээж авах, түүнийг шийдвэрлэх журамтай байх ба ирүүлсэн өргөдөл, гомдолд 48 цагаас илүүгүй хугацаанд хариу өгөх зохицуулалтыг журамд тусгасан байна.	+	+	+	+	Гомдол ба хүсэлт хүлээн авах утасны дугаар, холбоо барих хаяг зэрэг холбогдох мэдээллийг өөрийн албан ёсны вэб сайтад мэдээлсэн байх, үзэж шалгах линкийг бичиж ирүүлэх. Сүүлийн 6 сард ирүүлсэн өргөдөл, гомдлын тоо, шийдвэрлэлтийн талаар
15	НШ 6.6.1 НШ 6.6.2 НШ 6.6.3	Теле-худалдааны телевизийн хувьд: 6.6.1 Бараа бүтээгдэхүүнээ борлуулах төвтэй байх; 6.6.2.Тус төвийн хаяг, мэдээллийг нэвтрүүлгийн үеэр тодорхой илэрхийлэх; 6.6.3 Хүргэлтийн үйлчилгээ үзүүлэх боломжтой байх;	-	-	+	-	Бараа бүтээгдэхүүний борлуулах газрын хаяг байршлын талаарх мэдээлэл болон хэрхэн хэрэгжүүлж ажилладаг талаарх тодорхой мэдээлэл ирүүлэх
16	НШ 6.11.1 НШ 6.11.2.	Төлбөртэй телевизийн хувьд: 6.11.1 Үйлчилгээний төлбөр, цагийн хуваарь, арга хэмжээний мэдээллийг хэрэглэгч, үзэгчид ойлгомжтой тодорхой байдлаар мэдээлэх; 6.11.2. Цагийн хуваарьт заасан тухайн бүтээлээс өөр аливаа нэвтрүүлэг, контент дамжуулахгүй байх;	-	-	-	+	Төлбөрт үзэлтийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөлтэй төлбөртэй телевизийн хувьд үзэгчдэд холбогдох мэдээллийг хэрхэн хүргэдэг, 6.11.2. дахь заалтыг хэрхэн биелүүлж байгаа талаар тодорхой мэдээлэл ирүүлэх
	В	Телевизийн хөтөлбөрт тавигдах шаардлага хангаж ажилласан байдал					

17	ТХТШ 2.8 ТНЗСЗЖ 5.6 5.8	Теле-худалдааны телевизийн хувьд: 2.8 Теле худалдааны чиглэлээр төрөлжсөн телевизийн хөтөлбөр нь теле худалдааны нэвтрүүлгээр дагнасан байна. 5.6 Теле худалдааны нэвтрүүлгийг зөвхөн теле худалдааны чиглэлээр дагнасан төрөлжсөн арилжааны телевизээр нэвтрүүлнэ. 5.8 Теле худалдааны чиглэлээр төрөлжсөн телевизээр зөвхөн теле худалдааны нэвтрүүлэг бэлтгэн нэвтрүүлэх бөгөөд зар сурталчилгаа, бүтээгдэхүүн байршуулалт, хөтөлбөрийн ивээн тэтгэлт, төлбөр, захиалгат нэвтрүүлэг, нэвтрүүлэхгүй.	-	-	+	-	Төрөлжсөн нэвтрүүлгийн хувь хэмжээ болон хэрэгжилтийг хэрхэн хангаж байгаа талаар мэдээлэл ирүүлэх. Үнэлгээнд мониторингийн дүнг авч үзнэ.
18	ТХТШ 2.9	2.9 Телевизийн нэвтрүүлэгт тусгай дугаар ашиглах тохиолдолд нэвтрүүлгийн эхлэлд болон нэвтрүүлгийн дундуур тусгай дугаарын үнэ тарифыг дурдаж, үзэгчид харагдахуйц байдлаар тодорхой, ил тод мэдээлнэ.	+	+	+	-	Ашигладаг тусгай дугаар, үнэ тариф болон нэвтрүүлгийн үеэр хэрхэн мэдээлдэг талаар тайлбар, мэдээллээ бичнэ.
19	ТХТШ 2.10	2.10 "Урсдаг" болон "үгэн" хэлбэрийн мэдээ, мэдээллийг зөвхөн цаг үеийн мэдээ, мэдээллийн нэвтрүүлэг дундуур нэвтрүүлнэ. (Өргөн нэвтрүүлгийн үгэн болон урсдаг мэдээллийн форматад тавих шаардлага" MNS 6607:2016 стандартыг баримтлах)	+	+	-	-	Мэдээллийн хөтөлбөрийн дундуур үгэн болон урсдаг мэдээ, мэдээлэл нэвтрүүлдэг бол холбогдох стандартыг хэрхэн мөрддөг тухайгаа бичнэ
20	ТХТШ 2.12	Төлбөртэй телевизийн хувьд: 2.12 Төлбөртэй телевизийн хөтөлбөр тодорхой чиглэлээр дагнасан, төрөлжсөн байна.	-	-	-	+	Төрөлжсөн чиглэл, хөтөлбөрийн бүтцээ гаргаж ирүүлнэ. Үнэлгээнд мониторингийн дүнг авч үзнэ
21	ТХТШ 3.1 ба 3.2 3.4	3.1 Арилжааны телевизийн 7 хоногийн хөтөлбөрийн нийт цагийн 50 хувиас доошгүй нь, өргөн нэвтрүүлгийн телевизийн хувьд 60 хувиас доошгүй нь үндэсний бүтээл, нэвтрүүлэг байна. 3.4 Телевизийн 7 хоногийн хөтөлбөрийн нийт цагийн 30 хувиас доошгүй нь өөрийн бүтээл, нэвтрүүлэг байна...	+	+	-	-	Долоо хоногийн хөтөлбөрт үндэсний бүтээлийн эзлэх хувь, өөрийн бүтээлийн эзлэх хувиа тооцож ирүүлнэ. Өөрийн бүтээлийн талаарх мэдээллийг өргөдлийн маягын 6-дахь хүснэгтийг бөглөж ирүүлнэ. Үнэлгээ хийхдээ мониторингийн дүнг авч үзнэ.
22	ТХТШ 3.5	3.5 Төлбөртэй болон тодорхой чиглэлээр дагнасан, төрөлжсөн хөтөлбөртэй арилжааны телевизэд энэхүү шаардлагын 3.4-д заасан хувь хэмжээний шаардлага хамаарахгүй бөгөөд өөрийн редакцын бодлогын хүрээнд бэлтгэсэн тодорхой хэмжээний өөрийн бүтээл, нэвтрүүлэгтэй байна.	-	-	+	+	Кино, спорт, дуу хөгжим зэрэг тодорхой чиглэлээр төрөлжсөн хөтөлбөртэй телевизийн хувьд 7 хоногийн хөтөлбөрт эзлэх өөрийн бүтээлийн хувийг тооцож гаргаж ирүүлнэ. Өөрийн бүтээлийн талаарх мэдээллийг өргөдлийн маягын 6-дахь хүснэгтийг бөглөж ирүүлнэ. Үнэлгээ хийхдээ мониторингийн дүнг авч үзнэ.
23	ТХТШ 3.6	3.6 Аймгийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа эрхлэх телевизийн 7 хоногийн хөтөлбөрийн нийт цагийн 30 хувиас доошгүй нь тухайн орон нутгийн иргэдэд чиглэсэн, тухайн орон нутагт бүтээсэн мэдээ, мэдээлэл, бүтээл, нэвтрүүлэг байна.	+	+	-	-	Аймгийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа эрхлэж байгаа телевиз нь өөрийн 7 хоногийн хөтөлбөрт эзлэх өөрийн орон нутгийн иргэдэд чиглэсэн мэдээ, бүтээл, нэвтрүүлгийн эзлэх хувь, мэдээллийг гаргаж ирүүлнэ. Энэ нь өөрийн болон бусдын бүтээл байж болно. Үнэлгээнд мониторингийн дүнг авч үзнэ.
24	ТХТШ 3.10.1 3.10.4	3.10.1 (3.12.1) Жилд 180-200цагаас багагүй хугацааны үндэсний түүх, соёл, уламжлалын нэвтрүүлэг нэвтрүүлэх ба нийт цагийн 20 хувиас доошгүй нь шинэ бүтээл байна; 3.10.4 (3.12.3) Жилд 90-180 цагаас багагүй хугацааны танин мэдэхүйн нэвтрүүлэг нэвтрүүлнэ.	+	-	-	-	Монгол улс болон Улаанбаатар хот, Аймгийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа эрхэлдэг өргөн нэвтрүүлгийн телевиз нь цагийн хувьд ялгаатай. Хэрэгжилтийн байдлын талаарх мэдээллийг үзүүлэлт тус бүрээр ирүүлэх. Жнь: ямар нэвтрүүлэг, ямар хугацаатай гардаг, тухайн жилд гарсан шинэ бүтээл гм. Үнэлгээнд мониторингийн дүнг авч үзнэ.

25	ТХТШ 3.10.2 3.10.3 3.14	3.10.2 (3.12.2) Жилд 130-150 цагаас багагүй хугацааны 6+, 12+ насны ангилалтай (бага, өсвөр насны) хүүхдэд зориулсан нэвтрүүлэг нэвтрүүлэх ба нийт цагийн 20 хувиас доошгүй нь шинэ бүтээл байна; 3.10.3 Жилд 90 цагаас багагүй хугацааны балчир насны буюу 3+ насны ангилалтай хүүхдэд зориулсан нэвтрүүлэг нэвтрүүлнэ; 3.14 3+ насны ангилалтай хүүхдэд зориулсан нэвтрүүлэг нь үндэсний бүтээл байх ба нэг нэвтрүүлгийн үргэлжлэх хугацаа 15 минутаас ихгүй байна.	+	-	-	-	Монгол улс болон Улаанбаатар хот, Аймгийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа эрхэлдэг өргөн нэвтрүүлгийн телевиз нь цагийн хувьд ялгаатай байна. Хэрэгжилтийн байдлын талаарх мэдээллийг үзүүлэлт тус бүрээр ирүүлэх. Жнь: ямар нэвтрүүлэг, ямар хугацаатай гардаг, тухайн жилд гарсан шинэ бүтээл гм. Үнэлгээнд мониторингийн дүнг авч үзнэ
26	ТХТШ 3.17	3.17 Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 11.1, 11.2.4-ийн дагуу Монгол Улсын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа эрхлэх телевиз нь өөрийн хөтөлбөрөөр нэвтрүүлэх цаг үеийн мэдээ, мэдээллийн нэвтрүүлэг, хүүхдэд зориулсан нэвтрүүлэг, танин мэдэхүйн нэвтрүүлэг зэргийг дохионы хэлний хэлмэрчтэй эсхүл хадмал тайлбартай гаргах үе шаттай төлөвлөгөө боловсруулж, хэрэгжүүлнэ. Тус төлөвлөгөө, түүнийг хэрэгжүүлэх хугацааны хуваарийг ЗХ-нд ирүүлэх ба хагас жил тутам тайлагнана.	+	+	-	-	Монгол Улсын нутаг дэвсгэрт хамрах хүрээтэй өргөн нэвтрүүлгийн болон арилжааны телевизийн хувьд зарим тодорхой мэдээ, нэвтрүүлгээ дохионы хэлний хэлмэрчтэй эсхүл хадмал тайлбартай гаргах төлөвлөгөө ирүүлсэн, үүнийхээ дагуу нэвтрүүлсэн, тайлагнасан талаарх мэдээллээ гаргаж ирүүлнэ. Үнэлгээнд мониторингийн дүнг мө авч үзнэ.
27	ТХТШ 3.18	3.18 Телевизээр нэвтрүүлэх гадаадын аль нэг улсын кино нь тухайн телевизийн улиралд нэвтрүүлэх нийт гадаад киноны 50 хувиас хэтрэхгүй байна.	+	+	-	+	Хэрэгжилтийн байдлыг тооцож ирүүлэх нь нээлттэй. Үнэлгээнд мониторингийн дүнг авч үзнэ.
28	ТХТШ 4.2	4.2 Телевиз нь нэвтрүүлэг, бүтээл, рекламд МУ-ын холбогдох хуулиар хориглосон болон ӨНТХ-ийн 30.1.7-д заасан хөтөлбөрийн дүрэмд тусгасан зохисгүй контент бүхий зураг, дуу, авиа, дүрс бичлэг болон бүдүүлэг, доромж үг хэллэг байгаа эсэхийг хянаж, зохисгүй агуулга бүхий хэсгийг хасах, дууг хаах, дуут сигналаар орлуулах, дүрсийг бүдгэрүүлэх зэрэг техникийн хязгаарлалт хийх арга хэмжээ авна.	+	+	+	+	Энэ заалтыг хэрхэн хэрэгжүүлдэг, тухайлбал хэрхэн хянадаг, техникийн ямар хязгаарлалтыг авч хэрэгжүүлдэг талаар, сүүлийн 6 сард энэ чиглэлээр авсан арга хэмжээний талаарх статистик тоо баримттай ирүүлбэл сайн.
29	ТХТШ 4.4	4.4 Телевиз нь өөрийн хөтөлбөрөөр нэвтрүүлэх кино, нэвтрүүлгийн агуулгад насны ангилал тогтоож, түүнийг таних тэмдэг, тэмдэглэгээг "Өргөн нэвтрүүлэгт насны ангилал тогтоох, таних тэмдэг ашиглах шаардлага" MNS 6587:2016 стандартад заасны дагуу зурагтын дэлгэц дээр үзүүлж, олон нийтэд нэвтрүүлгийн насны ангиллын тэмдэг, тэмдэглэгээг сурталчилж, таниулна.	+	+	+	+	Насны ангилалын ямар тэмдэг, тэмдэглэгэ ашигладаг, хэрхэн сурталчилан таниулдаг талаар мэдээлэл.
30	ТХТШ 4.6 4.7	4.6 Хүүхдэд зориулсан кино, нэвтрүүлгийг оройн 21:00 цагаас хойш нэвтрүүлэхгүй. 4.7 Насанд хүрэгчдэд буюу 18-аас дээш насныханд зориулсан кино, нэвтрүүлгийг 06:00-22:00 цагийн хооронд нэвтрүүлэхгүй.	+	+	+	+	Ямар арга хэмжээ авч, хэрхэн хяналт тавьдаг талаар ирүүлэх Үнэлгээнд мониторингийн дүнг авч үзнэ.
31	ӨНТХ 23.1 ба 23.2	23.1. Радио, телевизийн үйлчилгээ эрхлэгч нь хөтөлбөрөө төрийн албан ёсны хэл болох Монгол хэлээр бэлтгэн дамжуулна. 23.2 Гадаад нэвтрүүлгийг дамжуулахдаа Монгол хэлээр дуу оруулсан, эсхүл бичгэн орчуулгатай байна.	+	+	+	+	Хэрэгжилтийн байдлыг үнэлгээнд авч үзнэ. Хэрэв гадаад хэл дээр нэвтрүүлэгтэй бол ямар нэвтрүүлэг гардаг, 7 хоногийн давтамж, бичгэн орчуулгатай нэвтрүүлдэг эсэх.
№		Телевизээр нэвтрүүлэх зар сурталчилгааны зохицуулалтын журам					

32	ТНЗСЗЖ 3.2 3.3 3.9 3.10	3.2 ..Тевизийн нэг цаг тутамд нэвтрүүлэх зар сурталчилгааны хугацаа 15 минутаас илүүгүй байна. 3.3 ..зар сурталчилгааны нэг блокийн үргэлжлэх хугацаа 5 минутаас илүүгүй байна. 3.9 Оргил цагаар (18:00-23:00) нэвтрүүлэх зар сурталчилгааны 80 хувиас доошгүй нь Монголд бүтээсэн байна. 3.10 Арилжаа, сурталчилгааны нэвтрүүлэг нь тухайн өдрийн нийт хөтөлбөрийн цагийн 15 хувиас илүүгүй байх ба нэвтрүүлгийг хөтөлбөрийн хуваарьт оруулсан байна.	+	+	-	-	Өөрсдөө тооцож ирүүлэх нь нээлттэй. Үнэлгээнд мониторингийн дүнг авч үзнэ.
33	ТНЗСЗЖ 3.12 3.13	3.12 Мэдээ, мэдээллийн нэвтрүүлгийг ӨНТХ-ийн 23.7, 23.8-д заасныг баримталж нэвтрүүлэх ба мэдээний дундуур зар сурталчилгаа нэвтрүүлэхгүй. 3.13 Мэдээ, мэдээллийн нэвтрүүлгийн багц хооронд 2-оос ихгүй зар сурталчилгааны блок нэвтрүүлж болно.	+	+	-	-	Хэрэгжилтийг хэрхэн хангаж байгаа талаар тайлбар, мэдээлэл ирүүлэх. Үнэлгээнд мониторингийн дүнг авч үзнэ.
34	ТНЗСЗЖ 3.14	3.14 Зар сурталчилгааны цагаас бусад үед нэвтрүүлж буй аливаа нэвтрүүлэг, киноны үеэр ивээн тэтгэгчийн болон аливаа бараа, бүтээгдэхүүн, үйлчилгээний зар сурталчилгааг баннер хэлбэрээр, урсдаг зар байдлаар дэлгэц дээр давхардуулан гаргахгүй байна.	+	+	-	-	Хэрэгжилтийг хэрхэн хангаж байгаа талаар тайлбар, мэдээлэл ирүүлэх. Үнэлгээнд мониторингийн дүнг авч үзнэ.
35	ТНЗСЗЖ 3.18	3.18 Телевиз нь бараа бүтээгдэхүүнийг студид байрлуулж үнэ хаялцуулах, дуудлага худалдаа зохион байгуулах хэлбэрээр сурталчлан борлуулах нэвтрүүлэг нэвтрүүлэхгүй.	+	+	+	-	Хэрэгжилтийг хэрхэн хангаж байгаа талаар тайлбар, мэдээлэл ирүүлэх. Үнэлгээнд мониторингийн дүнг авч үзнэ.
36	ТНЗСЗЖ 4.4 4.5	4.4 Балчир насны буюу 3+ насны ангилалтай нэвтрүүлэг, киноны дундуур зар сурталчилгаа нэвтрүүлэхгүй. 4.5 Бага насны буюу 6+ насны ангилалтай нэвтрүүлэг, киноны дундуур нэвтрүүлэх зар сурталчилгааны хугацаа нь 30 минутын хугацаанд таван минутаас илүүгүй байна. 5.4 Мэдээ, мэдээллийн нэвтрүүлгийн хараат бус байдлыг хангах зорилгоор мэдээ, мэдээллийн нэвтрүүлэгт (ивээн тэтгэлт авахгүй,) бүтээгдэхүүн байршуулалт хийхгүй.	+	+	-	-	Хэрэгжилтийг хэрхэн хангаж байгаа талаар тайлбар, мэдээлэл ирүүлэх. Үнэлгээнд мониторингийн дүнг авч үзнэ.
37	ТНЗСЗЖ 4.6	4.6 Хүүхдэд зориулсан нэвтрүүлэг дундуур холбогдох эрх бүхий байгууллагын гаргасан зөвлөмжийн дагуу чихэр, давс, транс болон ханасан тос ихээр агуулсан хоол, хүнсний бүтээгдэхүүн сурталчлахгүй, аливаа бараа, бүтээгдэхүүн байршуулахгүй.	+	+	-	-	Энэ заалтын хэрэгжилтийг хэрхэн хангаж, хяналт тавьж ажилладаг, ямар арга хэмжээ авдаг талаар мэдээллээ ирүүлэх
38	ТНЗСЗЖ 5.9	5.9 Төлбөртэй телевизээр бүтээгдэхүүн байршуулалт, хөтөлбөрийн ивээн тэтгэлтээс бусад зар сурталчилгаа, төлбөр, захиалгат нэвтрүүлэг, теле худалдааны нэвтрүүлэг нэвтрүүлэхгүй.	-	-	-	+	Хэрэгжилтийг хэрхэн хангаж байгаа талаар тайлбар, мэдээлэл ирүүлэх. Үнэлгээнд мониторингийн дүнг авч үзнэ.

|

|

шалгалтаар

|

|